# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

## 2025 оны жилийн эцэс

2025 оны 12 сарын 22-ны өдөр — Баруун-Урт

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| УИХ-ын тогтоол | | | | | |
| 1 | 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27 | 2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" -ийн дагуу ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд 13 заалт арга хэмжээг тусгаж 80 хувь хэрэгжүүлсэн байна. | 100 |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | |
| 2 | 2 | Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ | 1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах; | Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, Ариун Бичээс нийгэмлэг Сүхбаатар аймгийн ЗДТГазар, Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газар хамтран Асгат, Халзан, Баяндэлгэр, Баруун-Урт сумдын хараааны бэрхшээлтэй 15 иргэнд /үүний 5 хүүхэд/ брайль бичгийн сургалт зохион байгуулсан. | 100 |
| 3 | 3 | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" -ийн хэрэгжилтийг 1 удаа тайлагнасан. | 100 |
| | 4 | | 1.3. төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах. | Энэхүү арга хэмжээний үр дүнд байгууллагын ажилтан, албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хариуцлагын ухамсар сайжирч, дотоод сахилга, хяналт болон мэдээллийн хүртээмж нэмэгдсэнээр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа үр дүнтэй болсон. | 100 |
| 4 | 5 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | 1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" -ийн | 80 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ | Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах; | дагуу ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд 13 заалт арга хэмжээг тусгаж 80 хувь хэрэгжүүлсэн байна. | |
| | 6 | | 1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх. | Дэд хороо нь Төрийн албаны тухай хуулийн ёсзүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 заалтыг үндэслэн ажилтан, албан хаагчдын 100 хувийн саналаар байгууллагын ёс зүйн дэд хороог Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын А/04 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. | 100 |
| | 7 | | 1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах. | Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг 2025 оны төсөвт тусгуулахаар төсвийн төсөлд санал өгч, жилийн төлөвлөгөөнд тусгасан боловч төсвийн хэмнэлттэй холбогдуулан олгогдоогүй болно. | 80 |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 5 | 8 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлигийн 3 дугаар хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын түвшинд үндэсний бичгийн хэрэглээг шат дараатайгаар нэвтрүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ:<br>1.1. Байгууллагын дотоод хаягжилт, тэмдэглэгээ<br>•Байгууллагын нэр, хэлтэс, өрөөний хаягуудыг үндэсний бичгээр бичиж байршуулсан.<br>•Дотоод хаягжилтыг кирилл болон монгол бичгээр хослуулан ашиглаж байна.<br>1.2. Цахим орчин дахь мэдээлэл, сургалт<br>•"Кимо" хөрвүүлэгч программыг 3 лицензээр худалдан авч, суурин компьютеруудад суурилуулан өдөр тутмын үйл ажиллагаанд ашигласан. Програм суурилуулахад нийт 240.0 мянган төгрөг зарцуулсан.<br>•Байгууллагын цахим хуудас, пэйжид нийт 156 мэдээ, мэдээллийг кирилл болон монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлсэн.<br>1.3. Албан бичиг, зар сурталчилгаа, бэлгэ тэмдэг<br>•Байгууллагын нэрийн хуудас, албан бичгийн толгой, бэлгэ тэмдэг, самбар, зар сурталчилгаанд үндэсний бичгийг давхар ашиглаж байна.<br>•Албан бичиг, уриа лоозон зэрэгт үндэсний бичгийг хослуулан хэрэглэж байна. | 100 |
| ЗГ-ын тогтоол | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | 9 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-01-05<br>Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Байгууллагын нэршлийг монгол бичгээр хөрвүүлж, улсын хэмжээнд стандарт форматаар боловсруулан тайлан, мэдээлэл гаргахдаа ашигласан.<br>1.2.Цахим мэдээлэл, тайлан танилцуулга<br>•Байгууллагын хийсэн ажлын тайлан, төсөл, хөтөлбөрийг монгол бичгээр бичсэн хаягтай слайдаар танилцуулж, цахим хуудсанд нийтэлсэн.<br>•Байгууллагын цахим пэйж болон сайтад нийт 156 мэдээ, мэдээллийг кирилл болон монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлсэн.<br>1.3. Албан бичиг, шийдвэр<br>•Захирамжлалын нийт 122 баримт бичиг, зохион байгуулалтын 190 албан тоотыг хос бичгээр хөтөлсөн байна.<br>•Нийт ажилтан албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн хавтаст баримтыг 100% монгол бичгээр хаяглан өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>1.4. Монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг, сургалт<br>•Монгол бичгийн цахим сургалтад 9 албан хаагчид хамрагдсан, Угийн бичгийн сургагч багш бэлгэх сургалтанд 1 албан хаагч тус тус хамрагдаж унших, бичих чадвар нэмэгдсэн. хэрэгжилтийг 100% ханган ажилласан.<br>1.5. Гадна болон дотоод хаягжилт, нэрийн хуудас<br>•Албан хаагчдын албан тушаал, нэрийг кирилл болон монгол бичгээр зэрэгцүүлэн бичиж хаягжуулсан.<br>•Байгууллагын гадна самбар, өрөө тасалгааны нэршил, албан хаагчдын нэрийн хуудас, танилцуулга, ил захидлыг үндэсний бичгээр бэлтгэж хэвшүүлсэн.<br>•"Кимо" хөрвүүлэгч программыг 3 лицензээр худалдан авч, суурин компьютеруудад суурилуулан өдөр тутмын үйл ажиллагаанд ашигласан. Уг программыг суурилуулахад нийт 240.0 мянган төгрөг зарцуулсан. | 100 |
| 7 | 10 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-05-25<br>Дугаар 2022_203 | 1. 1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн | 1.1 ХХҮГазрын даргын 2022 оны 06-р сарын 15-ны өдрийн Б/34 тоот тушаалаар газрын дэд дарга Б.Сонинбаярыг үүрэгт ажлаас нь чөлөөлж дэд даргын орон тоо 2025 оны бүтэц орон тооноос хасагдаж батлагдсан. 1.2 Үйл ажиллагааны 2025 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж ХХҮЕГазарт хүргүүлсэн. 1.3 Байгууллагын | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх. | үндсэн чиг үүрэгт шууд хамаарал бүхий 2 сургалтыг цахимаар зохион байгуулсан. 1.4 Төсөл арга хэмжээний зураг, төсөвт хөрөнгө зарцуулаагүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж төсвийн сахилга харицлагыг чанд баримтлан ажилласан. | |
| 8 | 11 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-09-14<br>Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэний дагуу Монголын хүний нөөцийн менежментийн холбоо, "Дарь-овооны ээзд" төрийн бус байгууллагатай хамтран "Job Center" төвийг нээж орон нутгаас 3 сургагч бэлтгэн ажиллаж байгаа бөгөөд тус төвөөр 77 иргэнд ажилд зуучлах үйлчилгээнд, 102 иргэнд профайлинг үйлчилгээнд, 142 иргэнд АМЧБО ганцаарчилсан зөвлөгөө авсан байна. | 100 |
| 9 | 12 | Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай<br>2024-12-18<br>Дугаар 2024_217 | 2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай. | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн /erp.e-mongolia.mn/ цахим системээр бусад төрийн байгууллагуудтай албан бичгийг илгээж дотооддоо цахим системийг бүрэн ашиглаж байна. Нийгмийн халамжийн 14 үйлчилгээг /ehalamj.mn/ системийг, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг /ejob.gov.mn/ системийг тус тус ашиглан төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үйлчилж, үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж байна. Үр нөлөө : Цахим системд шилжсэнээр ирсэн явсан албан бичгийн шийдвэрлэлт хугацаандаа цаг алдалгүй илгээгдэж, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн олголтуудаа сар бүр хянах боломж бүрдсэн. Мөн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | албан хаагчид "Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан", E-mongolia систем, Төрийн албаны зөвлөлийн Төрийн албан хаагчийн портал сайт, ажлын байр, ажил олгогч, хөдөлмөр эрхэлтийг дэмжих үйл ажиллагааны ejob.gov.mn зэрэг системрүү нэвтрэхдээ Дан танилт, нэвтрэлтийн системийг ашиглан нэвтэрч хэвшсэн. | |
| 10 | 13 | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024-12-25 Дугаар 2024_246 | 5. 5. Орон нутгийн харьяалалтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр 2017-2024 оны хооронд зорчсон зардал болох нийт 1.3 тэрбум (нэг тэрбум гурван зуун сая) төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийг тооцооллын дагуу нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт 2025 онд багтаан шилжүүлэн барагдуулахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон төлбөр тооцооны нэгдсэн дүнг аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжилтийг тайлагнана. | 100 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 11 | 14 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо, Ариун Бичээс нийгэмлэг Сүхбаатар аймгийн ЗДТГазар, Хөдөлмөр, халамжийн үйчилгээний газар хамтран Асгат, Халзан, Баяндэлгэр, Баруун-Урт сумдын харааны бэрхшээлтэй 15 иргэнд /үүний 5 хүүхэд/ брайль бичгийн сургалт зохион байгуулсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас "Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалт"-г төр, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл 30 иргэнд 10 дугаар сарын 14-17-ны хооронд зохион байгууллаа. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй 967 иргэнд 209567.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгосон. | 100 |
| 12 | 15 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.6.2. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх | Нийгмийн халамжийн үйлчилгээг ehalamj.mn системд бүрэн шилжүүлсэн. Иргэд ehalamj.mn системээр хүсэлт гаргаснаар өөрийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн олголтыг хянах нөхцөл бүрдсэн. Ehalamj.mn системд 2025 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн 7474 иргэний үйлчилгээг шийдвэрлэсэн. Үүнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр 362 Нийгмийн халамжийн тэтгэмж 891 Ахмад настны хөнгөлөлт 3098 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 847 Насны хишиг 697 Алдарт эхийн одон | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | шатны байгууллагад даалгав. | 411 Эх, хүүхэд, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмжид 1168 үйлчилгээг шийдвэрлэсэн. | |
| 13 | 16 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33 | XIII.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах. | 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжиж аймгийн засаг даргын тамгын газраас 10,0 сая төгрөгийг батлуулан зарцуулсан. 1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2025 онд 24 удаа хуралдаж 201 хүүхэд орж, 44 хүүхэд асаргаанд шинээр хамрагдаж, 18 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болохыг шинээр тогтоож, 139 - хүүхэд асаргаа сунгагдсан. Мөн 31 хүүхдийн живхний хөнгөлөлтөд хамрагдах шийдвэр, 81 хүүхдийг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон шийдвэрүүдийг тус тус гаргасан байна. | 100 |
| | 17 | | XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй | 4.1 Байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх 135 хүнд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг улсын төсвөөс олгож байна.<br><br>4.2. Нийгмийн халамжийн сангаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 968 иргэнд 3919288.5 мянган төгрөг, эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны 283 хүүхдэд 1063907.3 мянган төгрөгийг тус тус олгосон.<br><br>4.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй 201 эцэг, эхчүүдэд хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих анхан шатны зөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүд өгсөн. | 100 |

| | |
|---|---|
| хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үзлэгт өөрөө төлбөрөө төлөөд 3 дугаар шатлалын эмнэлэгт үзлэг шинжилгээ хийлгэх боломжгүй зорилтод бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхдийг асран хамгаалагчийн хамтаар нэгдсэн унаагаар үйлчилж байр хоолны зардлыг нь шийдвэрлэж хамруулсан. Асгат, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр, Түвшинширээ, Баруун-урт сумдын засаг дарга нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үзлэгт хамрагдах зардлыг 100% даасан.<br><br>4.9 Байнгын асаргаа шаардлагатай 91 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг "Үйлст их" НҮТББ-тай хамтран сэргээн засах, нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамруулсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | |
| 14 | 18 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia.mn)-д албан бичгийн бланкийг шинэчлэн батлуулсан. Мөн албан тушаалын индексийн тохиргоог системд хийж албан бичиг боловсруулах нөхцлийг хангасан. Газрын даргын нэр дээр 2 жилийн хугацаатай Tridium компанийн тоон гарын үсэг авч, даргын албаны компьютерт программыг суулгаж, тохируулгыг бүрэн хийж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. Энэ хугацаанд 12 албан хаагчийн нэвтрэх эрхийг сэргээж, албанаас чөлөөлөгдсөн 4 алба хаагчийн эрхийг цуцалж, шинээр томилогдсон 3 алба хаагчийн мэдээллийг бүртгэн эрх, код олгож, албан тушаал өөрчлөгдсөн 4 албан хаагчийн албан тушаалыг өөрчилж, одоогоор 39 алба хаагч бүртгэлтэй төлөвтэй байна. Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем erp.e-mongolia.mn-ийн тоон гарын үсэг ашиглах, баримт бичиг боловсруулах, албан бичгийн бланк боловсруулж илгээх, батлуулах үйл ажиллагааны талаар нийт 30 албан хаагчдад биечлэн зохион байгуулсан. Байгууллагын ажилтнуудад зориулан | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | программ хангамж болон сүлжээ ашиглалт, хэрэглээний аюулгүй байдлын талаар цахим сургалтын PPT бэлдэж ERP системийн байгууллагын “файл” цэсэнд байршуулсан. | |
| 15 | 19 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 | XIY.1.3.Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | Төрийн байгууллага болон төрийн бус байгууллагааар гүйцэтгүүлэх ажлын тайланг нэгдсэн сангийн системд тогтоосон хугацаанд бүрэн байршуулах, чанар, агуулгыг хянах, шаардлагатай засвар шинэчлэлийг хийх, хэрэглэгчийн санал хүсэлтийг тогтмол хүлээн авч шийдвэрлэх ажлыг хариуцсан албан тушаалтанд төвлөрүүлэн гүйцэтгүүлж хэрэгжилтийг ханган ажилласан. | 100 |
| 16 | 20 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2.“Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах. | Шил ажиллагааны системд ил тод байршуулах нийт 5 төрлийн 87 мэдээллээс байгууллагад хамааралтай 3 төрлийн 34 заалтын мэдээг улирал бүр бүрэн байршуулж ажилласнаар 1-р улиралд 91,2 хувь, 2-р улиралд 100 хувь, 3-р улиралд 99 хувь тус тус үнэлэгдсэн. Төрийн байгууллагуудын цахим хуудас нэгдсэн нэг загвартай болсонтой холбогдуулан https://www.gov.mn/mn/organization/sba-halamj сайтын хөгжүүлэлтийг хийж, танилцуулга 6, хууль эрх зүй 7, ил тод байдлын 5, төрийн үйлчилгээ 25, байгууллагын алба хаагчдын мэдээлэл зэрэг нийт төрлийн 43 мэдээлэл бэлтгэн оруулж, 211 мэдээ, мэдээлэл бэлтгэж нийтэлж, нийт хуудсанд хандсан хүн давхардсан тоогоор 50,632 байна. Мөн уг сайтын шинэчлэлт хийгдэж e-mongolia системд холбогдсон тул e-mongolia.mn/org/sukhbaatar-hueg вэбсайтын хөгжүүлэлтийг 2025 оны 09 сарын 15-ны өдрөөс хийж, 9 төрлийн 92 мэдээллийг бэлтгэж оруулан, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 27 мэдээ, мэдээллийг нийтэлж, нийт хуудсанд хандсан хүн давхардсан тоогоор 5,264,670 байна. Байгууллагын www.facebook.com/SBXXYGazar/ пэйж хуудсанд 299 төрлийн постер мэдээлэл, видео шторк зэргийг Фотошоп, Canva, Catcup, Power Point, Paint, AI, Irfanview программуудыг ашиглан бэлтгэн байршуулж, давхардсан тоогоор 1,076,008 хүн үзэж танилцсан байна. Одоогоор тус пэйж нь 6,2 мянган дагагчтай болсон байна. Байгууллагын youtube | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | @СүхбаатараймагXXYГазар суваг нээн 44 төрлийн шторк, видео бичлэг бэлтгэж байршуулсан. Шилэн дансны тайлагналтад сар бүр хяналт хийхэд төсвийн үйл ажиллагааны-159, халамжийн сангийн-129, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн-138, нийт 426 мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. | |
| 17 | 21 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1 | 28.3.1."Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэхээр төрийн байгууллагыг төлөөлж аймгийн засаг дарга, үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Ажил олгогч эздийн холбооны тэргүүн нар болон тэдгээрийн бүрэн эрхэт төлөөлөгчид Монгол Улсын үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, ХТХ, 13, 14, 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн бизнесийн таатай орчин бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүн амын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны нийтлэг асуудлаар Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 2025-2026 онд мөрдөх хамтын хэлэлцээрийг байгуулж, хамтын гэрээ хэлэлцээрийг бүртгэн баталгаажуулсан. | 100 |
| 18 | 22 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1 | 19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн талаар ) | Малжуулах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 130 иргэний материалыг сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шаардлага хангасан өрхүүдийн мэдээллийг аймгийн статистикийн газрын 2024 оны жилийн эцсийн тоон мэдээлэлтэй тулгаж 13 сумын 90 малчин өрхийг хамруулж 720,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож 180 ажлын байр бий болсон. | 100 |
| 19 | 23 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-07-30 Дугаар 2025_10 | 14.4.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинээр байгуулах хэлэлцээрийн төслийг боловсруулан 2025 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг | Засгийн газрын 370 дугаар тогтоолийн хүрээнд Сүхбаатар аймгийн 2025-2026 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээр байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдлыг нийгмийн түншлэгч талууд хамтран дүгнэлт гаргахад хамтран ажиллаж бүх сумдад хамтын хэлэлцээрийг байгуулах хамтын гэрээг хэрэгжүүлэх төлөвлөөг боловсруулан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд засаг даргын нөөц сангаас 30 сая | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, "Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | төгрөгийг зарцуулахыг хэлэлцээрт тусган ажиллаж байна. Хэлэлцээрийн түвшин төлөвлөгөө гарган уул уурхайн ажилтан ажил олгогчдын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулан ажилласан. | |
| | | | ЗГ-ын албан даалгавар | | |
| 20 | 24 | ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-03-07 Дугаар 2025_03 | 1.8. 1.8. Бүс, орон нутгийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 359 дүгээр тогтоолын 2.2-т заасны дагуу 2025 онд тухайн аймаг/нийслэлд хувиарлагдсан нийт төсвийн 0.3 доошгүй хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна гэсний дагуу орон нутгийн төсвөөс 100,0 сая төгрөг батлуулан залуучуудын гарааны биенесийг дэмжих санхүүжилт олгохоор журам гарган ажиллаж байна. "Халамжаас хөдөлмөрт" бодлогын хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. • 17 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил олгох сургалтад хамруулсан. • 223 иргэнийг байнгын болон түр ажлын байранд, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт тус тус хамруулсан. | 100 |
| | 25 | | 1.11. 1.11. Зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг шинээр нэвтрүүлж, бага орлоготой өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх; | Зорилтот өрхийн иргэдэд дараах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:<br>•Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авагч 45 иргэнийг ажилд зуучилсан.<br>•50 иргэнд амьдрах ухааны сургалт зохион байгуулж, 33 өрхөд 59400,0 мянган төгрөгийн өрхийн үйлдвэрлэл эрхлэх төсөлд хамруулсан.<br>•345 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулсан. | 100 |
| | 26 | | 1.12. 1.12. Аймаг, нийслэлийн хэмжээнд оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх, нийгмийн идэвх, оролцоог дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | Залуучуудын гарааны бизнесийг дэмжих "Старт ап" арга хэмжээг зохион байгуулж 48 залуучууд хамрагдаж 9 баг аймагт, 3 баг Дорнод аймагт бүсийн сургалтад тус тус хамрагдаж хурдасгуур арга хэмжээнээс 8 баг шалгарч 97,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнд: ХЭДС-аас 2 төсөлд 30,000.0 мянган төгрөг, бүсийн Старт ап арга хэмжээнд 1 төсөлд 17,000.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 5 төсөлд 50,000.0 мянган төгрөг тус тус олгосон. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2024 онд 1 төсөл дэмжигдэж байсан бол 2025 онд 5 төсөл дэмжихээр төлөвлеснөөс 8 төсөл дэмжигдэж орон нутгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажилласны үр дүнд 11 ажлын байр шинээр бий болсон. Мэргэжлийн боловсролын сургуулийн 10 оюутанг " Бүрэн мандах шарга" ХХК, "Дорнод шим агро" ХХК-д дадлга хийлгэхээр гурвалсан гэрээ байгуулан. Дадлага хийсэн хгуацаанд цалин олгож НДШ-ийг төлсөн нөхцөлд ХЭДС-аас 3 сарын НДШ-ийг ажил олгогчид буцаан олгох талаар танилцуулж хөдөлмөрийн тухай хуулийн 63-р хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх талаар мэдээлэл өгч ажилласан. | |
| | 27 | | 1.14. 1.14. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, арчилж ургуулах ажлыг эрчимжүүлэх; | Байгаль орчныг хамгаалах, хүүхдүүдэд эко хүмүүжил олгохоор гэр бүлээрээ "Эвтэй гэр бүл-Эрүүл байгаль арга хэмжээг зохион байгууллаа. Байгууллагын хувиарт газарт "ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨР"-ийн хүрээнд 50 ширхэг улиас мод тарьж, хүүхдүүддээ мод тарих ач тусын талаар сургалт зохион байгууллаа. Арга хэмжээний явцад хүүхдүүд өөрсдийн гараар мод тарьж, арчилгаа хийхэд идэвхтэй оролцсон нь тэдэнд бодит мэдлэг олгохоос гадна байгальтай харьцах зөв хандлагыг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүллээ. | 100 |
| 21 | 28 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай 2025-06-18 Дугаар 2025_01 | 2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; | Шил ажиллагааны shilen.gov.mn системд 9 хэрэглэгчийг бүртгэж, мэдээллүүдийг улирал бүр хариуцсан мэдээллүүдийг бүрэн оруулж хэвшсэн. /1-р улиралд 91%, 2-р улиралд 100%, 3-р улиралд 99% үнэлэгдсэн/ Энэ хугацаанд хяналт тавьж ажиллахад алба хаагчдаас мэдээллийг хугацаанд нь оруулаагүй, буруу алдаатай мэдээлэл оруулсан алба хаагч байхгүй болно. | 100 |
| | 29 | | 2.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл | Байгууллагын ёс зүйн дэд хороо нь Төрийн албаны тухай хуулийн ёсзүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 заалтыг үндэслэн ажилтан, албан хаагчдын 100 хувийн саналаар байгууллагын ёс зүйн дэд хороог Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын А/04 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" -ийн дагуу ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөнд 13 заалт арга хэмжээг тусгаж 80 хувь хэрэгжүүлсэн | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллагааг идэвхжүүлэх; | байна. 2025 онд байгууллагын ажилтан, албан хаагчидтай ёс зүйн болон хариуцлагын гэрээг байгуулж, хэрэгжилтийн ханган ажилласан. Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн болон төрийн үйлчилгээний стандартын талаар 2 удаа сургалт зохион байгуулж бүх албан хаагчдын бүрэн хамруулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний дагуу байгууллагын хамт олны дунд дотоод цахим группыг нээж урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар, зөвлөмж, хуулийн 8 мэдээлэл байршуулсан. Удирдлагын манлайлалын хүрээнд ажилтнуудын дунд талархлын хуудас арга хэмжээг хэрэгжүүлж нийт 8 албан хаагчид талархлын хуудас ирсэн байна. | |
| | 30 | | 2.5.Төрийн албан хаагчийг хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэхгүй байх; | Төрийн албан хаагчийг томилох, шилжүүлэх, чөлөөлөх үйл явцыг Төрийн албаны тухай хууль, тогтоомж, албан тушаалын шаардлагын дагуу, Мерит зарчмыг чанд баримтлан томилж байна. Тушаал шийдвэрийг шийдвэрийн хяналтын хуудсаар шат дараалан хууль эрхзүйн, утга найруулгын холбогдох санхүүгийн заалтыг хянан баталгаажуулж байна. | 100 |
| | 31 | | 2.6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу батлагдсан төсвийн дагуу төсвийг үр ашигтай зарцуулан ажилласан. | 100 |
| 22 | 32 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03 | 1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх | Албан хаагчдын ёс зүйн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн үйл ажиллагааг улс төрөөс ангид, мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх чиглэлээр ёс зүйн дэд хорооноос 2 удаа сургалт зохион байгуулж албан хаагчдын бүрэн хамруулсан. Нийгмийн халамжийн үйлчилгээг 100 хувь цахимжуулж төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд шат дамжлагагүй хөнгөн шуурхай хүргэж байна. Мөн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох хугацаа, олгосон тайлн мэдээг байгууллагын цахим хуудсуудад тогмиол мэдээлэн ажиллаж байна. | 100 |
| | 33 | | 1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу батлагдсан төсвийн дагуу төсвийг үр ашигтай зарцуулан ажилласан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өгч, үр дүнг тооцож ажиллах | | |
| 23 | 34 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар 2025-07-08 Дугаар 2025_03 | 4.5. Хөдөлмөр эрхлээгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч, хөдөлмөрийн статистикийн тогтолцоог бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанарыг сайжруулж, ажиллах хүчний болон ажлын байрны судалгааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах | Тус онд 444 аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс 1585 ажлын байрны захиалга ирсэнийг бүртгэлтэй ажил хайгч иргэдэд мэдээлэх, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын пэйж болон Facebook цахим хуудсанд 12 удаа байршуулж 28519 иргэнээс хандалт авч 79 удаа шэйр хийсэн байна. | 100 |
| | Нийт | | | | 97 |

ТАНИЛЦСАН:
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ө.БАТ-АМГАЛАН

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:
ХШҮ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ц.НАРМАНДАХ